



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Номгон сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/59/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал

Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

НОМГОН СУМЫН ЭМТ-ИЙН
ЭРХЛЭГЧ Х.МЯДАГМАА ТАНАА

2022.02.22 № 120

танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Номгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас Номгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаатай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээллээс тусдаа санхүүгийн ба санхүүгийн бус мэдээлэл байхгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн тушаалаар хөрөнгийн тооллогын комисс байгуулан тооллого хийсэн боловч тооллогын бүртгэлд комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй, комиссын ажлын тайлан байхгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас 61,047,083 төгрөгийн бараа материал хүлээн авч зарлага гаргахдаа эд хариуцагчийн тайлан бэлтгээгүй зэрэг нь иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

016023228



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


С.ЦЭРЭНБАЯР



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	90.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	999.9
	Нийт хөрөнгийн дүн	1,090.1
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,090.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,090.1
	Үйл ажиллагааны орлогын дүн	593.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	519.9
	Үйл ажиллагааны үр дүн	73.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	-18.2
	Үйл ажиллагааны нийт үр дүн	54.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,035.2
	Тайлант оны үр дүн	54.9
	Эцсийн үлдэгдэл	1,090.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	471.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	443.8
	Үйл ажиллагааны ЦМГ	27.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	27.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	372.0
	Урсгал зардал	
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31.3
	Улсын төсвөөс санхүүжих	354.6
	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8.3
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Номгон сумын ЭМТ-ийн эрхэм зорилго нь: “Бүртгэгдсэн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш чанартай хүртээмжтэй нэг ч иргэнийг орхигдуулахгүй хүргэх” гэж тодорхойлжээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг



Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас 61,047,083 төгрөгийн бараа материал хүлээн авч зарлага гаргахдаа эд хариуцагчийн тайлан бэлтгээгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 459.3 сая төгрөгийн 33 мэдээллээс мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудалгүй байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,077.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 16.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1,060.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, алдааг давтан гаргахгүй байх талаар 1 зөвлөмж хүргүүллээ.

7.1 Залруулсан алдаа

Бараа материалын тайланд 16.4 сая төгрөгийн эм дутуу зарлагадсаныг залруулсан.

7.2 Албан шаардлага

1.ЭМТ-ийн эрхлэгчийн 2021 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн А/18 дугаар тушаалаар хөрөнгийн тооллогын комисс байгуулан тооллого хийсэн боловч тооллогын бүртгэлд комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй, комиссын ажлын тайлан байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас 61.1 сая төгрөгийн бараа материал хүлээн авч зарлага гаргахдаа эд хариуцагчийн тайлан бэлтгээгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.1.1 "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.



7.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Шилэн дансны тухай хууль

Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээлэлд дараа жилийн төсвийн төсөл мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 " дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.4 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1					1	
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1					1	

7.5 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн



A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	1,077.3	1	16.4	-	-	2	1,060.9	1	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	4	1,077.3	1	16.4	-	-	2	1,060.9	1	-